

**1939 ОНЫ ХАЛХЫН ГОЛЫН ДАЙНЫ ТУХАЙ
ШИНЭ ТАЙЛБАР УУ, ЭСВЭЛ ТҮҮХИЙГ
ГУЙВУУЛСАН ХЭРЭГ ҮҮ?**

(О.С.Смысловын “Халхын гол: Мартагдсан үйл явдлын
хөшигний цаана” номын шүүмж)

Ю.В.КУЗЬМИН, М.ЗУЛЬКАФИЛЬ

Товч агуулга: Энэхүү өгүүлэл нь О.С.Смысловын 1939 оны Халхын голын дайны тухай зохиогчийн тайлбар, дайны шалтгаан, цэргийн дарга нарын үүрэг, байлдааны үйл явдалд оролцогчдын цэргийн хохирлын талаарх шинэ номын тухай шүүмж юм.

Түлхүүр үг: Зохиолч О.С.Смыслов, Халхын голын дайн, Г.К.Жуков, дайны шалтгаан, үнэлэлт, арга зүй, оросын түүх бичлэг

Оросын түүх бичлэгт 1939 оны Халхын голын дайны (эсвэл цэргийн морголдоон гэж оороор үнэлдэг) сэдвийг судлах шинэ үе эхэлсэн гэж үздэг. 1939 онд монгол-манжийн хил дээр болсон байлдааны үйл явдлын 75 жилийн ой Орос, Монгол, Японы судалгааны ажлыг эрс идэвхжүүлэх, энэ дайныг тайлбарлах, үнэлэлт дүгнэлт өгөхөд чухал алхам хийсэн чамбай бүтээлүүд (В.В.Грайворонский, М.И.Гольман, В.Г.Дацышен, С.Г.Лузянин, В.Г.Мильбах, М.Коломиец, В.И.Кондратьев, Б.В.Базаров, Л.В.Курас, Е.Л.Катасонова, С.В.Карасев, А.П.Суходолов, М.П.Рачков болон бусад) гарахад чухал нөлөө үзүүлжээ [1; 3; 4; 5; 6]. Эдгээр бүтээлүүд өнгөрсөн үеийн түүхэн бүтээлүүдэд шүүмжлэлтэй хандаж, архивын баримт бичгүүд болон дурсамжуудад дүн шинжилгээ хийж, энэ асуудлын хүрэн дэх тулгамдсан асуудлуудыг судлах шинэ сэдвүүдийг илрүүлэхэд чиглэгдсэн байдаг. Маргаан, мэтгэлцээн өрнүүлэх зорилгоор дайныг бүхэлд нь шинээр тайлбарлах, мөн цэргийн олзлогсод, залхаан шийтгэх, цэргийн хохирол, дайны үйл явдлын тодорхой хэсгүүдэд үнэлэлт өгөх зэрэг тусгай асуудлуудыг санал болгосон юм [3; 4; 5]. Тухайлбал, Халхын голын дайн бол Дэлхийн хоёрдугаар дайны эхлэл байсан гэсэн шинэ дүгнэлт нь судлаачдын анхаарлыг татах чухал асуудал болж байна [2, С.74-96]. Тэр бүтээлүүдэд худал хуурмаг баатарлаг гавьяа байхгүй бөгөөд Дэлхийн хоёрдугаар дайны түүхэн дэх дайны шалтгаан, байлдааны үйл явдлуудын эзлэх байр, Халхын голын байлдааны үр дагаврын талаар бодитой, бүтээлч дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн нь Оросын болон дэлхийн түүхэнд чухал ач холбогдолтой болжээ. Москва, Санкт-Петербург, Улаанбаатар, Эрхүү, Чита,

Улаан-Үүд хотод зохион байгуулагдсан олон улсын хэмжээний томоохон хурлууд дайн, эсвэл мартагдсан цэргийн мөргөлдөөнийг олон нийтэд илүү ойлгомжтой, мөн Оросын үндэсний түүхэнд илүү үнэ цэнэтэй болгож чадсанаараа чухал ач холбогдолтой юм [7].

Гэхдээ 1939 оны Халхын голын цэргийн мөргөлдөөний түүхийн талаарх зарим судалгааны бүтээлд судлаачид түүхэн үйл явдлыг өөрчлөх гэсэн шүүмжлэлтэй хандлагын давалгаанд автагдаж нэг түүхэн домгийн оронд эрс өөр, бүр эсрэг тэсрэг байр суурь бүхий домгийг бодож олсон байдаг. 2017 онд “Вече” хэвлэлийн газар цэргийн түүхч, чөлөөнд байгаа дэд хурандаа, зохиолч О.С.Смысловын энэ дайн дахь Г.К.Жуковын болон фронтын бүлгийн захирагч, армийн жанжин Г.М.Штерн, бригадын захирагч М.А.Богданов нарын үүрэг, цэргийн мөргөлдөөний шалтгаан, талуудын цэргийн хохирол болон дайны ажиллагаанд оролцсон бусад нөлөө бүхий хүмүүсийн тухай шинэ тайлбар, үнэлэлт дүгнэлт өгсөн “Халхын гол. Мартагдсан мөргөлдөөний хөшигний цаана” хэмээх нэг сэдэвт бүтээлийг хэвлэн гаргажээ.

Олег Сергеевич Смыслов Нисэхийн дээд сургууль, Агаарын цэргийн академийг төгсөж, олон жил Оросын армид (ПВО, ВВС) алба хаасан, 2004 оноос Оросын зохиолчдын эвлэлийн гишүүн, “Василий Сталин. Нэрийг барьцаалсан нь”, “Гитлерийн тав дахь цуваа. Кутеповоос Власов хүртэл”, “Генерал Абакумов. СМЕРШ-ийн төгс хүчит эзэн”, “Дайны нуувчийн үнэн”, “Нисэгчдийн эсрэг нисэгчид”, “1941 оны өмнө. Гитлер Орос руу явж байна”, “Германы лагерь дэх үхэл ба олзлогсод”, “Котовский. Хувьсгалын Робин Гуд”, “Жагсаалын өмнө буудаж алах”, “Оросын тэнгэрийг хамгаалагчид. Нестеровоос Гагарин хүртэл”, “Сталины олзлогдсон генералууд” болон бусад 30 гаруй номын зохиогч юм.

О.С.Смыслов шинжлэх ухааны хялбаршуулсан бичлэгийн төрлөөр голлон бичдэг, түүхэн үйл явдлуудыг нэлээд өргөн хүрээнд сонирхдог нь тодорхой байна. Энэ бүтээлд зохиогч Оросын улсын цэргийн архивын цөөнгүй баримт материалыг ашигласан, энэ асуудлын хүрээнд бичигдсэн бүтээлүүдээс хангалттай эш татсан, 1939 оны Халхын голын дайны түүхэн үйл явдлуудын тухай дүгнэлтүүдийн шинэ хувилбарыг санал болгосноороо онцлогтой юм. Дээр нь энэ бүтээлийн хэвлэгдэх хувь нь ч хангалттай тул олон уншигчийн сонирхлыг татаж чадах нь тодорхой. Тиймээс тусгайлан шүүмж бичих боломжтой гэж үзлээ. Энэ номын үнэлэлт дүгнэлтийн ихэнх хэсэг нь маргаан дагуулах учраас түүхч-мэргэжилтнүүдийн анхаарлыг татах, олон нийтийн маргаан мэтгэлцээний сэдэв болох боломжтой юм.

Бидний бодлоор зохиогчийн 1939 оны Халхын голын цэргийн мөргөлдөөн тохиолдлын шинжтэй байсан гэсэн дүгнэлт нь маргаантай гэдэг нь ойлгомжтой. Энэ дүгнэлт бол О.С.Смысловын дүгнэлт биш бөгөөд тэрээр В.Вартановын үзэл бодолд үндэслэн ийм дүгнэлт хийж байгаа хэрэг юм. Тэрээр нийт 10 мянган хүний бүрэлдэхүүнтэй явган цэргийн хоёр хороо болон нэмэлт хүчний ангиудаар БНМАУ-ыг болон Өвөр Байгалийг эзлэн авах боломжгүй гэж үздэг ажээ (с.25). Зохиолд “Бидний бодлоор гэнэт гэж хэлмээргүй дэгдсэн цэргийн тулалдаан тохиолдлын шинжтэй бөгөөд энэ нь бүс нутгийн хилийн шугамын эмх замбараагүй байдалтай холбоотой байсан. Хэдэн жилийн турш монгол-манжийн талууд энэ асуудлын хүрээнд зөвлөлдөх уулзалтуудыг хийсэн боловч нэгдсэн нэг үзэл бодолд хүрч чадаагүй байсан юм” (с.25) гэж тэмдэглэжээ. Энэ бол үнэхээр тийм биш гэдэг нь тодорхой. Энэ бүс нутагт Японы түрэмгийлэн эзлэх бодлого тохиолдлын шинжтэй биш, урьдчилж нарийн төлөвлөсөн, тодорхой логик дараалалтай байсан. Манжжоу-Гогийн тоглоомын улс байгуулагдаж, энэ хараат улсад Японы байр суурь улам бэхжсэний дараа цаашдын түрэмгийлэн эзлэх бодлого нь эхэлж, тэр нь жил болгон улам хүчтэй болсоор иржээ. Зөвлөлт-манжийн болон монгол-манжийн хил дээр 1931 оноос эхлэн цэргийн халдлага, хилийн мөргөлдөөний тоо байнга нэмэгдсээр ирсэн бөгөөд бүгд Япон болон Квантуны армийн талаас эхэлсэн байдаг. Үүнийг өнөөдөр Японы түүхчид ч хүлээн зөвшөөрдөг.

О.С.Смысловын бодлоор “чухам энэ саруудад Японы гадаад харилцааны алба (дипломат) Греман ба Их Британитай хамтын ажиллагааны нөхцөлийн талаар ширүүн наймаа хийж байв. Яг энэ үед Япон Хятадад нэлээд хүнд дайныг үргэлжүүлж, хүн болон техникийн хувьд багагүй хохирол амссан. Ийм хүнд нөхцөлд япончуудад хэдийгээр түрэмгийлэн эзлэх бодлого байсан ч өөрийнхөө гол зорилгоос татгалзаж саад учруулах өөр нэг томоохон дайн дэгдээх сонирхол байгаагүй гэдэг нь тодорхой”(с.27) юм. Харин эсрэгээр Японы цэргүүд 1938 онд Хасан нуурын ойролцоо ялагдал хүлээсний дараа байлдаанаа дахин сэргээж, маш богино хугацаанд амжилтанд хүрэх зорилготой бага зэргийн дайн дэгдээхийг зорилго болгож байжээ. Энэ бол тэдний олон улсын тавцан дахь нэр хүндийг бэхжүүлэх, Япон-Германы хэлэлцээр дэх байр суурийг хүчтэй болгоход нөлөөлнө гэж үзэж байжээ. Тэд Баруунд нэлээд нарийн түвэгтэй дипломат нөхцөл байдалтай байгаа ЗХУ Монголыг тийм хэмжээнд шийдвэртэй, хүчтэй хамгаалах болно гэж бодоогүй. Японы талынханд ирээдүйн дайны талбарт шууд хүрэх төмөр зам болон авто зам зэрэг тактикийн хувьд давуу тал байсан бол зөвлөлтийн цэргүүд

мөргөлдөөн болох бүс нутгаас нэлээд зайтай байснаас гадна шаардлагатай тээврийн дэд бүтэц байгаагүй.

О.С.Смысловын номын гол санаа нь дивизийн захирагч (дараа нь корпусын захирагч), 1939 оны 6-9 сард Халхын голд Японы цэргүүдийг бутцохисон Монгол дахь армийн бүлэглэлийн захирагч Г.К.Жуковын үүргийг харлуулж үгүйсгэхэд чиглэгдсэн байна. Зохиогч үүнийг түүний Халхын голын үйл явдлын талаарх дурсамжуудын тодорхой бус хэсгүүд, дурсамжид гардаг томоохон цэргийн дарга нарыг болон тэдний энэ байлдааны ажиллагаан дахь үүргийг зориуд оригдуулах замаар харуулахыг хичээсэн байна.

О.С.Смысловын Г.К.Жуковын дурсамжууд болон ялангуяа зөвлөлтийн үеийн хэд хэдэн түүхэн бүтээлүүдэд байлдааны ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн армийн 2-р зэргийн жанжин Читад байгаа штаб ба фронтын бүлэглэлийн захирагч, албан тушаалын болон цэргийн цолын хувьд дээд түвшний цэргийн дарга Григорий Михайлович Штерн, мөн штабын дарга, бригадын захирагч М.А.Богдановын үүргийн талаар тусгаагүй гэдгийг зөвшөөрч болно. Зохиогч

Г.М.Штерн болон М.А.Богданов нар цэргийн ондор боловсролтой, Испанийн байлдаанд цэргийн туршлага хуримтлуулсан тул цэргийн мэдлэг, чадварын хувьд Г.К.Жуковоос илүү байсан гэдгийг шударгаар тэмдэглэсэн байна. Сүүлийн үеийн Оросын судалгааны бүтээлүүдэд орчин үеийн судлаачид энэ нөхцөл байдлыг тодорхой хэмжээнд харгалзан үздэг боловч нэрт маршалд хүндэтгэлтэй хандаж, түүний цэргийн гавьяаг үнэлдэг нь ажиглагддаг.

Зохиогч Г.К.Жуковт цэргийн авьяас байгаагүй гэдгийг тэмдэглэж, Халхын голд цэргийг мэргэжлийн түвшинд удирдаж чадаагүй нь цэргийн академик мэдлэг дутмаг, байлдааны туршлагагүй байсантай холбоотой гэж үзжээ. Тэрээр хошууч В.А.Новобранцын дурсамжийг үндэслэн: “Корпусын захирагч Жуков холбооны техник хэрэгслүүдийг үл тоож, оронд нь Наполеон шиг зөвхөн офицерүүдийг ашиглаж байв... Жуков фронт даяар өөрийн штабын офицерүүдийг тал тал тийшээ явуулдаг байлаа. Заримдаа зөвхөн захирагч штабт өөрийнхөө штабын даргын хамт үлддэг байв” (с.111) гэж тэмдэглэсэн байна. Армийн жанжин дивизүүдийг ч, бригадуудыг ч, тусгай хороодыг ч захирч байгаагүй, харин зөвхөн ангиудыг удирдаж байсан талаар тэмдэглээд: “Жуков ямар ч академид суралцаж байгаагүй. Орос-Японы дайны туршлагыг бие дааж судлах зав чөлөө гараагүй бололтой. Куропаткины замаар явсан” (с.113) гэж бичжээ. Зохиогч Г.К.Жуковын үйл

ажиллагааг шүүмжлэхдээ түүний цэргийн авьяас чадвар, бий болсон байлдааны нөхцөл байдлыг цаг тухайд нь ойлгох, шуурхай, шийдвэртэй арга хэмжээ авах чадварыг дутуу үгэлсэн нь тодорхой байна. Г.К.Жуковын үйл ажиллагааны зөвхөн сүүдэртэй талд нь гол анхаарлаа хандуулж, бүх зүйлийг нэг л өнцгөөс харж, сөрөг өнгө аяс хэт давамгайлсныг үнэхээр шударга бус гэж үзэхээс өөр аргагүй юм. Өгч буй тодорхойлолт нь сэтгэлийн хөдөлгөөнд хэт автагдсан, хэт нэг талыг барьсан сөрөг хандлагатай байна.

О.С.Смысловын бодлоор жанжин Штерн болон бригадын захирагч Богданов нар Жуковын багш нь байжээ. “Харамсалтай нь Григорий Константинович өөрөө давших байлдааны ажиллагааны төлөвлөгөөг бие дааж боловсруулах чадваргүй байсан” (с.242). учраас “Халхын голын байлдааны ажиллагааны төлөвлөгөөний эцсийн хувилбар нь армийн хоёрдугаар зэргийн жанжин Штерн, бригадын захирагч Богданов, корпусын захирагч Жуков болон фронтын, армийн бүлэглэлүүдийн бусад офицерүүдийн хамтын хөдөлмөрийн үр дүн”(с.234) байжээ. Зохиогч он жилүүд өнгөрсний дараа Штерн мартагдаж, түүний нэр ой санамж болон дурсамжуудаас арилж, зөвхөн Г.К.Жуков үлдэх болно гэж шударга тэмдэглэснийг онцлон хэлэх хэрэгтэй. Цэргийн түүхийн бүтээлүүдэд энэ асуудлыг нэлээд өргөн хүрээнд хөндөж эхэлсэн бөгөөд янз бүрийн үзэл бодол байгаа учраас баримтад тулгуурласан тусгай судалгаа хийх шаардлагатай юм.

Зохиогч Г.К.Жуковын шийдвэр дэндүү харгис байсан, ямар ч үндэслэлгүй олон тооны буудаж алах шийтгэл тулгаж байсан, дараа нь тэднийг Штерний санаачлагаар оршөөсөн талаар онцлон тэмдэглэжээ. “Эл номыг зохиогчийн бодлоор Жуковт ямар ч цэргийн мэдлэг, авьяас байгаагүй, гэхдээ бүх юмыг хатуу шийдвэр, эр зориг, шургуу зангаараа хөдөлгөж байжээ. “Григорий Константинович хянагчийн дүрд тоголж шуурхай захирах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нь оролцож, Москвад мэдээлэл бичээд корпусын захирагч Фекленког сэмхэн солиулж байсан. Тэрээр гэсгээн шийтгэхэд ч шуурхай байлаа. Ер нь Мехлис Жуков хоёрын бичгийн хэлбэр ч адилхан байжээ... Сүүлд Сталин чухам түүнээс өөрийнхөө шийдвэрийг зоригтой гүйцэтгэгчийг, шийдвэртэй байх гэсэн утгаараа өөртөө ойр дотно “амьтан”-ыг, түшиг тулгуур болох чадвар, хатан зоригийг олж харсан байдаг” (с.92-93) гэжээ. Мөн зохиогч долдугаар сарын байлдааны үеийн халз давшилт ямар ч үр ашиггүй болж, асар их хэмжээний цэргийн хохирол амссан гэж дүгнэжээ. Орчин үеийн түүхийн бүтээлүүдэд Г.К.Жуковын талаарх энэ сэдэв өөрийн гэсэн дэмжигчидтэй бөгөөд түүхийн бүтээлүүдэд тодорхой тусгалаа олсон байдаг.

Бидний бодлоор Г.К.Жуковын цэргийн авьяасын, түүний дотор Халхын голын байлдааны ажиллагааны үеийн авьяас, чадварын тухай маргах нь ямар ч утгагүй юм. Бид түүний үйл ажиллагаанд алдаа дутагдал, хэтэрсэн явдал, буруу шийдвэр байсныг үгүйсгэхгүй. Гэхдээ түүний 1939 оны Хахын голын байлдааны ажиллагааны үеийн хөргийг зөвхөн “хараар будах” боломжгүй, учир нь түүхэн баримтууд түүнд ийм боломж олгохгүй гэдэг нь тодорхой. Харин агуу их жанжины тухай зөвхөн сөрөг шинжүүдийг жагсаахгүйгээр, янз бүрийн баримтат болон дурсамжийн эх сурвалжуудыг (Г.К.Жуковын тухай эерэг ба сөрөг үнэлгээнүүд) харьцуулж судлах нь хамаагүй ашигтай болох байсан. Эс тэгвэл “гарамгай жанжины” тухай нэг домгийн оронд эсрэг тэсрэг шинж чанар, тодорхойлолтыг агуулсан өөр нэг домог бий болох нь ойлгомжтой. Энэ бүхэн нь Халхын голын дайны үйл явдлыг гүнзгийрүүлэн судлах, шүүмжлэлтэй хандах, тухайн үеийн цэргийн нэрт зүтгэлтнүүдийн үүргийг болон цэргийн хохирол, дайны шалтгаан, үр дагаврыг тодруулах шаардлага тулгарсныг харуулж байна.

Зохиогч Г.К.Жуков болон штаб, түүний ажлын хоорондох харилцааны асуудлыг нэлээд тодорхой авч үзсэн байна. Тэрээр өөрийнхөө цэргийн албан тушаалын эхний үед штабын ажлын үүргийг гүйцэд үнэлээгүй нь үнэн. Харин 1939 оны Халхын голын дайны үед, ялангуяа цэргийн өндөр албан тушаалд томилогдсоны дараа цэргийн үйл ажиллагааны энэ төрөлд чухал ач холбогдол өгч байлаа. “Г.К.Жуков Монголд онцгой корпусын болон армийн бүлэглэлийн хэмжээнд цэргийн даргын анхны байлдааны туршлага хуримтлуулсан. Чухам энд, ирээдүйн цэргийн жанжин Халхын голд 57 дугаар онцгой корпусын штабт ажиллаж байсан,эсвэл академийг дөнгөж төгсөж ирсэн цэргийн дээд боловсролтой боловсон хүчнүүдийг хайрлаж хамгаалахын оронд сэтгэл дундуур байх ямар нэгэн шалтаг олж, тэднийг үргэлж цэргийн шүүн таслах газар руу илгээж байв”(с.102). Энд зохиогч байлдааны ажиллагааны хоёрдугаар зэргийн хүмүүсийн тухай дурсан ярьж байгаа мөртлөө яагаад түүний нэгдүгээр орлогч, штабын дарга Богдановын тухай огт дурдахгүй өнгөрсөн нь өөрийн эрхгүй сонирхол татах асуудал мөн. “Ингэхэд маршал, цэргийн жанжин дурсамж тэмдэглэлүүдэд өөрийнхөө штабын болон бусад штабын дарга нарын тухай сануулахыг яагаад мартсан бэ? Энд Г.К.Жуковын мартамхай чанарын цаана “хуучин”-ыг эргэн дурсахыг үл хүсэх санаа нуугдаж байна гэсэн таамаглал дэвшүүлэх л үлдэх болно. Өөрөөр хэлбэл өөрийнхөө чадваргүй удирдлагыг ч, хэрээс хэтэрсэн харгис чанарыг ч, бүдүүлэг, зөрүүд занг ч санахыг хүсээгүй. Тиймээ, Халхын голын гол ялагчийн титмийг өөр нэг урагшгүй амьтантай хуваалцах ямар шаардлага байна?” (с.117).

Зохиогчийн бодлоор Жуковын Дэлхийн нэгдүгээр дайны цэргийн туршлага Монголд огт тохироогүй, харин 57 дугаар онцгой корпусын захирагчийн албан тушаалд томилогдох цорын ганц хүн бол дивизийн захирагч К.К.Рокоссовский байжээ (с.78). “Г.К.Жуковын Халхын гол хүртлэх хашиж байсан бүх албыг хүндэтгэх бүрэн боломжтой, харин нь тэрээр морин цэргийн сайн захирагчаар л үлдэх байсан. Монгол дахь байлдаан цэргийн даргаас арай өргөн хүрээний мэдлэг чадвар шаардсан бөгөөд үүнд ирээдүйн маршалд цэргийн боловсрол ч, түүнд тохирсон байлдааны туршлага ч дутсан юм”(с.70). Г.К.Жуковыг Монголд эхлээд хянагчийн хувьд илгээсэн бөгөөд зөвхөн хоёр долоо хоногийн дараа дивизийн захирагч Н.В.Фекленкогийн оронд корпусын захирагчаар томилсон байдаг. Зохиогч Г.К.Жуков ажлын нөхцөл байдлын талаар Москвад маш олон мэдээлэл бичсэн бөгөөд тэр нь ажлын үр дүнг шийдэж байсан талаар бичжээ (с.67). “Бүгдийг тунгаан үзэхэд Г.К.Жуков Фекленкогийн тухай: “Их л зүтгэдэг, гэхдээ зохион байгуулалт тааруу, тодорхой зорилгогүй” гэж хэлсэн нь үнэн ажээ. Гэхдээ энэ бүхэн нь ирээдүйн жанжины хувьд маш ашигтай байв. Ер нь хэлж өгөх, туслах бол нэг хэрэг, харин өөрийнхөө Москвад бичсэн мэдээллүүдээр “корпусын захирагчийн зөөлөн сандлын хөлийг байнга хөрөөдөх” нь өөр хэрэг шүү дээ. Жуков нэг зуурч авбал салахгүй гэдэг нь нууц биш байжээ”(с.56). Зохиолч О.С.Смысловын таамаглалаар Г.К.Жуков дивизийн захирагч Фекленкогийн “хажууд сууж”, түүний байрыг эзэлж, Монголд явах томилолтыг Жанжин штабын дарга М.В.Захаровын (ирээдүйн ЗХУ-ын маршал) туслахын зөвлөмжөөр авсан, Японы цэргүүдийг бутцохих цэргийн ажиллагааг Жуковын оролцоотойгоор Штерн ба Богдановын штабууд боловсруулжээ. Энд Халхын голын дайны үеийн Г.К.Жуковын үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт нь урьдаас тааварласан буруу таамаглал гэдэг нь маш тодорхой байна.

Хэрэв энэ бүтээлийг зохиогч бидний дайны түүхээс “өөсэв” эрж хайх, түүнийг гажуудуулах зорилготой гадаадын судлаач байсан бол бүгдийг зөвөөр ойлгож болно. Харин энэ тохиолдолд зохиогч Оросын армийн ахлах офицер асан, Оросын цэргийн түүхийг маш сайн мэддэг, энэ сэдвээр олон арван ном бичсэн хүн юм. Халхын голын дайны үеийн цэргийн ажиллагааг амжилттай гүйцэтгэсний төлөө ЗХУ-ын Баатар цолыг хүртсэн, цаашид цэргийн жанжины гайхамшигтай албан тушаалд дэвшиж чадсан Ялалтын нэрт маршалыг харлуулахын тулд тодорхой шалтаг, шалтгаан байх ёстой.

Орчин үеийн судлаачдын Зөвлөлтийн үеийн хүмүүсийн ажлыг шүүмжлэх, судалж буй асуудлын талаарх өөрсдийн үзэл бодлыг нотлох хүсэл эрмэлзэлд автагдах хандлага ажиглагдаж байна. Энэ тохиолдолд зохиогч өөрийнхөө үзэл бодолд тохируулан “хамгийн зохимжтой” баримт мэдээлэл, онцлог шинжийг сонгох бус, эсрэгээр иж бүрэн түүхэн эх сурвалжууд, баримт бичгүүд болон дурсамж тэмдэглэлүүдийг ашиглах ёстой байсан. Шинэ, үнэ цэнэтэй эх сурвалжуудыг судалгааны эргэлтэнд оруулах, янз бүрийн үзэл бодолд шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийх нь бие хүн болон үзэгдлүүдэд үнэн бодитой үнэлэлт өгөх боломж олгодог.

Бидний бодлоор О.С.Смысловын судалгаа өөрөө бүтцийн хувьд нэлээд оновчгүй, намтрын талаарх хэт дэлгэрэнгүй баримт мэдээллүүдийг оруулжээ. Энэ нь хэдийгээр хэрэгтэй боловч тэднийг тайлбараар өгөх, эсвэл тусгай эх бичвэрээр ялгах шаардлагатай байсан. Мөн эх сурвалжийг нь тодорхой заагаагүй асар их хэмжээний баталгаа нотолгоогүй, эргэлзээтэй ишлэл ашигласан нь учир дутагдалтай юм. Бидний шүүмжилж буй энэхүү бүтээл нь хэмжээнээс хэтэрсэн олон ишлэлд дарагдсан, нэг ишлэлээс дараагийн ишлэл руу огцом шилжсэний хамт зохиогчийн өөрийн гэсэн үнэлэлт дүгнэлт, бүтээлч дүн шинжилгээ маш бага байна. Үүнийг номын нэг гол дутагдал гэж хэлж болно.

Мэргэжлийн түүхчид зохиогчийн бүх үнэлэлт дүгнэлтийг хүлээж авахгүй, тэд маргаантай, хэлэлцүүлэг өрнүүлэх шаардлагатай байж болно. Харин туршлага багатай уншигч зохиогчийн бүх дүгнэлтийг түүхэн үнэн гэж хүлээн авч, Оросын цэргийн түүхийн талаарх буруу зөрүү, худал хуурмаг төсөөллийн хавханд орох бүрэн боломжтой. Г.К.Жуковын үйл ажиллагааг бүх талаас нь судалж, шүүмжлэлтэй хандах шаардлагатай гэдгийг бид үгүйсгэхгүй. Харин зөвхөн нэг талыг барьж, сөрөг талаас нь түүхэн үнэлэлт өгөх нь байж болохгүй зүйл юм. Бид янз бүрийн дурсамж тэмдэглэлд тодорхой бус зүйл, нэг баатрыг хэт дөвийлгөн үзүүлж, нөгөөг хэт шүүмжилдэг нь байнга ажиглагддаг зүйл гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тиймээс үнэлэлт дүгнэлт түүхийн үүдээс тэнцвэрт байдлыг хадгалсан байх ёстой. Г.К.Жуковын дурсамжууд үзэл суртлын хатуу хяналтан дор бичигдсэн, хэвлэгдэхээс өмнө маш өндөр түвшинд хянагдсан нь тодорхой. Тиймээс харамсалтай нь дурсамжийн бүх зүйл зөвхөн зохиогчоос шалтгаалаагүй гэдгийг хэлэх хэрэгтэй.

Өнөөдөр Оросын түүхийг мушгин гуйвуулах, түүний дотор цэргийн түүхийг, мөн Дэлхийн хоёрдугаар дайны үеийн цэргийн мөргөлдөөнийг гуйвуулах

хандлага Оросын ч, ялангуяа Барууны түүх бичлэгт нийтийг хамарсан, чиглэсэн зорилготой шинжийг агуулсаар байна. Мэргэжлийн түүхчдийн судалгааг хэт бага хувиар хэвлэж байгаа учраас олон нийтэд хангалттай хэмжээнд хүрч чадахгүй байна. Шинжлэх ухаан-танин мэдэхүйн хялбаршуулсан бүтээлүүд асар их хувиар хэвлэгдэж, Интернет дэх нийтлэлүүд нийт уншигчдын түүхийн мэдлэгийг төлөвшүүлэхэд маш хүчтэй нөлөөлж байгаа нь ирээдүйд манай орны хувьд сөрөг үр дагавар авчрахыг үгүйсгэх аргагүй.

Бидний бодлоор Оросын болон Монголын түүхчид хамтран томоохон хэмжээний нэг сэдэвт бүтээл бичих, мөн “1939 оны Халхын голын дайн” хэмээх тусгай нэвтэрхий толь бэлтгэх цаг болжээ. Энэ нь Оросын цэргийн түүхийг болон түүний олон улсын харилцааны түүхийг, нөлөө бүхий цэргийн дарга нарын бодит түүхэн үүргийг санаатайгаар, дур зоргоороо гуйвуулахаас зайлсхийх боломж олгох нь дамжиггүй.

Ном зүй

1. Катасонова Е.Л.Халхин-Гол: 70 лет спустя. Историография проблемы/ Е.Л.Катасонова // Япония. Ежегодник, 2009, - №38. – С.271-
2. Кузьмин Ю.В.Война на Халхин-Голе 1939 г.(май - сентябрь) как начало Второй мировой войны/Ю.В.Кузьмин, М.П.Рачков, А.П.Суходолов// Вопросы теории и практики журналистики. - 2014. - №2. – С.74-96
3. Мильбах В.С. Политические репрессии комначсостава Забво и 57-го особого корпуса (1937-1938)/ В.С.Мильбах.- Иркутск: Из-во ИрГТУ, 2002.- 268 с.
4. Свойский Ю.М.Военнопленные Халхин-Гола. История бойцов и командиров, прошедших через японский плен/Ю.М.Свойский.- М.: Русский фонд содействия образованию и науке, 2014.- 320 с.
5. Сеченов И.В. Отдельный пограничный батальон в боях на Халхин-Голе, 1939 год./ И.В.Сеченов.- Иркутск: Географ, 2014.- 108 с.
6. Суходолов А.П. Монголия и русско-монгольские отношения первой половины XX века: проблемы истории и историографии/ А.П.Суходолов, Ю.В.Кузьмин; под ред. проф. М.П.Рачкова. – Иркутск: Изд-во БГУ, 2016.- 318 с.
7. Халхин-Гол 1939 г. в мировой истории и международных отношениях: история, историография, концепции. Мат. межд. конф. 23 мая 2014 г.// Вестник Международного центра азиатских исследований. Вып.19. – Иркутск: Изд-во ВСГАО, 2014.- 286 с.

ЗОХИОГЧИД

1. БАДАМСАМБУУ Г. МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Түүхийн тэнхимийн докторант.
2. БАЯРМАА Г. МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Түүхийн тэнхимийн докторант.
3. ГАНЧИМЭГ А. ХБНГУ-ын Хумбольдтийн их сургуулийн Ази, Африк судлалын хүрээлэнгийн Төв Ази судлалын тэнхим дэх Монгол судлалын салбарын эрхлэгч, доктор.
4. ЖИГМЭДДОРЖ Э. МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Түүхийн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D).
5. ЗУЛЬКАФИЛЬ М. МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн зөвлөх профессор, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D).
6. ИНЕС ШТОЛПЕ. ХБНГУ-ын Бонн их сургууль (University of Bonn)-ийн Дорно дахин ба Ази судлалын хүрээлэнгийн Монгол, Түвд судлалын тэнхимийн профессор, доктор.
7. КУЗЬМИН Ю.В. ОХУ-ын Байкалын их сургуулийн профессор, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D).
8. ПУНСАЛДУЛАМ Б. Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Түүхийн хүрээлэнгийн Бүс нутаг, орчин үеийн түүхийн салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор.
9. УРАНГУА Ж. МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Түүхийн тэнхимийн профессор, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D).
10. ШИЛИ Хэрэйд. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын төвийн судлаач, доктор (Ph.D).
11. ЭРДЭНЭБААТАР Мянгад. БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн Түүхийн салбарын дэд профессор, доктор.
12. ЭНХСАРУУЛ Л. БНХАУ-ын Ардын их сургуулийн Түүхийн салбарын докторант.